

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 21, 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг энэ хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын санхүү, эдийн засагт үзүүлэх үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж төсвийн тодотголын төсөлтэй хамт төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхөөр төсвийн сахилга бат алдагдах эрсдэлтэйг анхааруулж, энэ хуулийн төсөл батлагдсанаар төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангахад нөлөөлөх эсэх, мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Монгол Улсын 2026 оны төсөвт тодотгол хийх эсэх, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын цалинг ирэх 3 жилд нэмэгдүүлэхэд анхаарах, мөн шинээр ажлын байр, дэд бүтцийн байгууламжийг нэмэгдүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

